

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/112/НА- СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын

Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер М.Алтантуяа

Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Должмаа

Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	8
3 . САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5.1. Албан шаардлага.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ШШЕГ	Шүүхийн шинжилгээний ерөнхий газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2025.02.25 № 2/29
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 70707 (Шүүхийн шинжилгээ) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс баталсан 492,944.2 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, санхүүжилтийн 99.3 хувь буюу 489,674.4 мянган төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулж, зардлын хэмнэлтийн 3,269.8 мянган төгрөгийг оны улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 33 дугаар тогтоолоор тус байгууллагад 2023 онд шилжиж ирсэн хуучнаар Мэргэжлийн хяналтын газрын 1,172,168.2 мянган төгрөгийн өртөг бүхий барилгыг 74,625.0 мянган төгрөгийн газрын хамт Баянхонгор аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтэст балансаас баланст шилжүүлсэн байна.

5020214

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Баянхонгор аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн даргын 2024 оны жилийн эцсийн ажлын гүйцэтгэл, үр дүнг Шүүх шинжилгээний Ерөнхий газрын дарга 94.75 хувиар үнэлсэн байна.

Тус байгууллага нь нярвын ажлыг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэгч мэргэжилтнээр гүйцэтгүүлж байгаа нь анхан шатны баримтын бүрдэл дутуу байх, бараа материалын тайланг зөрүүтэй бэлтгэх эрсдэлтэй байна.

Баянхонгор аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн 2024 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>10,240,950.00</u>	<u>5,487,500.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	10,240,950.00	5,487,500.00
351	Түүхий эд материал	4,747,450.00	2,792,100.00
35130	Эм боох материал	4,747,450.00	2,792,100.00
354	Хангамжийн материал	5,493,500.00	2,695,400.00
35410	Бичиг хэргийн материал	1,023,500.00	225,400.00
35440	Түлш, шатах тослох материал	2,000,000.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	2,470,000.00	2,470,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,352,066,331.70</u>	<u>288,006,517.25</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,352,066,331.70	288,006,517.25
392	Биет хөрөнгө	1,246,566,331.70	257,131,517.25
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,279,031,192.67	106,862,990.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-77,928,982.08	-62,823,972.87
39203	Авто-тээврийн хэрэгсэл	10,000,000.00	151,361,352.95
39204	Хуримтлагдсан элэгдэл	-312,500.00	-4,062,500.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	71,110,647.90	85,464,089.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	-38,570,463.98	-22,531,442.66
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9,029,014.29	6,651,800.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,792,577.10	-3,790,800.07
393	Биет бус хөрөнгө	105,500,000.00	30,875,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	114,742,200.00	40,117,200.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-9,242,200.00	-9,242,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,362,307,281.70</u>	<u>293,494,017.25</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,362,307,281.70</u>	<u>293,494,017.25</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,362,307,281.70	293,494,017.25
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	22,015,100.00	22,015,100.00
51101	Өмч: - төрийн	22,015,100.00	22,015,100.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,340,292,181.70	271,478,917.25
51210	Өмнөх үеийн үр дүн	1,340,292,181.70	1,340,292,181.70
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-1,068,813,264.45
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,362,307,281.70</u>	<u>293,494,017.25</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,635,798,802.67	671,220,569.95
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,267,725,202.67	168,276,369.95
120	Нийтлэг татварын бус орлого	1,251,263,202.67	168,276,369.95
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	1,246,793,202.67	168,276,369.95
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	4,470,000.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,462,000.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,462,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,000,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	368,073,600.00	502,944,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	364,398,600.00	492,944,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	364,398,600.00	492,944,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,675,000.00	10,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,675,000.00	10,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	387,579,476.93	523,071,167.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	387,579,476.93	523,071,167.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	375,682,640.30	517,902,362.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	232,686,878.74	370,778,093.00
210101	Үндсэн цалин	124,434,479.74	191,417,453.00
210102	Нэмэгдэл	81,329,000.00	112,110,640.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,612,999.00	32,326,900.00
210104	Урамшуулал	11,310,400.00	34,923,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,951,300.00	9,638,999.00
210201	Тэтгэврийн даатгал	00.00	2,611,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	307,299.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	153,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	153,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,951,300.00	6,413,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,853,724.13	40,600,430.57
210301	Гэрэл, цахилгаан	947,398.13	1,498,822.57
210302	Түлш, халаалт	30,487,170.00	37,400,704.00
210303	Цэвэр, бохир ус	1,419,156.00	1,700,904.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,515,058.50	25,812,499.60
210401	Бичиг хэрэг	6,268,600.00	5,798,100.00
210402	Тээвэр, шатахуун	14,233,300.00	16,368,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	189,058.50	699,999.60
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,080,000.00	1,201,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,744,100.00	1,745,100.00
2105	Нормативт зардал	14,564,980.00	14,655,350.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13,361,580.00	11,955,350.00
210502	Хоол, хүнс	993,200.00	2,700,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	210,200.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,433,700.00	4,405,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	138,200.00	105,600.00
210604	Урсгал засвар	20,295,500.00	4,300,000.00
2107	Томилот, зочны зардал	4,946,900.00	6,600,000.00

210702	Дотоод албан томилолт	4,946,900.00	6,600,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,053,102.00	2,088,573.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	458,450.00	1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	275,100.00	675,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	268,552.00	267,873.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	51,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,000,000.00	00.00
210807	Газрын төлбөр	00.00	123,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,676,996.93	43,322,817.21
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,675,000.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	700,000.00	10,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	31,301,996.93	33,322,817.21
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,896,836.63	5,168,804.83
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,247,250.00	1,899,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,247,250.00	1,899,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,649,586.63	3,269,804.83
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,248,219,325.74	148,149,402.74
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	1,216,962,667.19
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	1,216,962,667.19
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-1,216,962,667.19

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	374,535,600.00	502,944,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,462,000.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,462,000.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,462,000.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,462,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	368,073,600.00	502,944,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	364,398,600.00	492,944,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	364,398,600.00	492,944,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,675,000.00	10,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,675,000.00	10,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	374,535,600.00	484,994,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	374,535,600.00	484,994,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	362,638,763.37	479,826,095.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	232,686,878.74	370,778,093.00
210101	Үндсэн цалин	124,434,479.74	191,417,453.00
210102	Нэмэгдэл	81,329,000.00	112,110,640.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,612,999.00	32,326,900.00
210104	Урамшуулал	11,310,400.00	34,923,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,951,300.00	9,638,999.00

210201	Тэтгэврийн даатгал	00.00	2,611,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	307,299.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	153,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	153,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,951,300.00	6,413,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,853,724.13	40,600,430.57
210301	Гэрэл, цахилгаан	947,398.13	1,498,822.57
210302	Түлш, халаалт	30,487,170.00	37,400,704.00
210303	Цэвэр, бохир ус	1,419,156.00	1,700,904.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,426,658.50	22,069,299.60
210401	Бичиг хэрэг	6,430,000.00	5,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	16,233,300.00	14,368,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	189,058.50	699,999.60
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,080,000.00	1,201,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,494,300.00	800,000.00
2105	Нормативт зардал	12,111,500.00	13,200,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,658,300.00	10,000,000.00
210502	Хоол, хүнс	993,200.00	2,700,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	460,000.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	39,933,700.00	4,850,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,500,000.00	50,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	138,200.00	500,000.00
210604	Урсгал засвар	20,295,500.00	4,300,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,946,900.00	6,600,000.00
210702	Дотоод албан томилолт	4,946,900.00	6,600,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,053,102.00	2,088,573.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	458,450.00	1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	275,100.00	675,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	268,552.00	267,873.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	51,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,000,000.00	00.00
210807	Газрын төлбөр	00.00	123,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,675,000.00	10,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,675,000.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	10,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,896,836.63	5,168,804.83
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,247,250.00	1,899,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,247,250.00	1,899,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,649,586.63	3,269,804.83
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	17,949,300.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	17,949,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	17,949,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	17,949,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	17,949,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-17,949,300.00

7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	22,015,100.00	00.00	92,072,855.96	114,087,955.96
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	22,015,100.00	00.00	92,072,855.96	114,087,955.96
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,248,219,325.74	1,248,219,325.74
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	22,015,100.00	00.00	1,340,292,181.70	1,362,307,281.70
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	22,015,100.00	00.00	1,340,292,181.70	1,362,307,281.70
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	22,015,100.00	00.00	1,340,292,181.70	1,362,307,281.70
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,068,813,264.45	1,068,813,264.45
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	22,015,100.00	00.00	271,478,917.25	293,494,017.25

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	492,944,200.00	489,674,395.17	3,269,804.83	99.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	492,944,200.00	489,674,395.17	3,269,804.83	99.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	491,045,200.00	489,674,395.17	1,370,804.83	99.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	373,923,200.00	370,778,093.00	3,145,107.00	99.16
210101	Үндсэн цалин	193,942,000.00	191,417,453.00	2,524,547.00	98.70
210102	Нэмэгдэл	112,591,200.00	112,110,640.00	480,560.00	99.57
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,466,900.00	32,326,900.00	140,000.00	99.57
210104	Урамшуулал	34,923,100.00	34,923,100.00	00.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,639,600.00	9,638,999.00	601.00	99.99

210201	Тэтгэврийн даатгал	2,611,800.00	2,611,200.00	600.00	99.98
210202	Тэтгэмжийн даатгал	307,300.00	307,299.00	01.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	153,600.00	153,600.00	00.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	153,600.00	153,600.00	00.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,413,300.00	6,413,300.00	00.00	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,694,900.00	40,600,430.57	94,469.43	99.77
210301	Гэрэл, цахилгаан	1,550,000.00	1,498,822.57	51,177.43	96.70
210302	Түлш, халаалт	37,401,600.00	37,400,704.00	896.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	1,743,300.00	1,700,904.00	42,396.00	97.57
2104	Хангамж, бараа материалын зардал	22,069,300.00	22,069,299.60	00.40	100.00
210401	Бичиг хэрэг	5,000,000.00	5,000,000.00	00.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	14,368,300.00	14,368,300.00	00.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	700,000.00	699,999.60	00.40	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,201,000.00	1,201,000.00	00.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	800,000.00	800,000.00	00.00	100.00
2105	Нормативт зардал	13,200,000.00	13,200,000.00	00.00	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,000,000.00	10,000,000.00	00.00	100.00
210502	Хоол, хүнс	2,700,000.00	2,700,000.00	00.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00	00.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,800,000.00	22,800,000.00	00.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,000,000.00	18,000,000.00	00.00	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	500,000.00	500,000.00	00.00	100.00
210604	Урсгал засвар	4,300,000.00	4,300,000.00	00.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	6,600,000.00	6,600,000.00	00.00	100.00
210702	Дотоод албан томилолт	6,600,000.00	6,600,000.00	00.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,118,200.00	2,088,573.00	29,627.00	98.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000.00	1,000,000.00	00.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	675,200.00	675,200.00	00.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	268,500.00	267,873.00	627.00	99.77
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	51,000.00	22,000.00	29,000.00	43.14
210807	Газрын төлбөр	123,500.00	123,500.00	00.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1899000.00	1899000.00	00.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,899,000.00	1,899,000.00	00.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,899,000.00	1,899,000.00	00.00	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	492,944,200.00	489,674,395.17	3,269,804.83	99.34
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	492,944,200.00	489,674,395.17	3,269,804.83	99.34
131001	Улсын төсвөөс санхүүжих	492,944,200.00	489,674,395.17	3,269,804.83	99.34
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	12	11	01	91.67
620001	Удирдах ажилтан	01	01	00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	11	10	01	90.91

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00

3 . САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

"Шүүхийн шинжилгээний байгууллагын чадамжийг сайжруулж, дэвшилтэд техник, технологи бүхий шинжилгээний лабораториудыг ашиглан тусгай мэдлэг, мэргэжлийн хүрээнд аливаа шинжилгээг хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гарган мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх" эрхэм зорилготой тус байгууллага нь төрийн тусгай 11 албан хаагчтай үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг дарга Б.Батдорж, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Гантулга нар зурж, нярваар туслах ажилтан Д.Дэлгэрмаа ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай, Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Шүүх шинжилгээний албаны, Төрийн албаны тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үргэлжлүүлэн мөрдсөн;
- Засгийн газрын тогтоолоор албан хаагчдын цалин нэмэгдсэн;
- ТБОНӨХБАҮХАТХ-ийн шинэчилсэн найруулгыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр баталж, 2024.01.01-ний өдрөөс эхлэн мөрдсөн;
- Сангийн сайдын 2024 оны 229, А/211 дугаар тушаалаар Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, төсвийн эдийн засгийн ангилал, санхүүгийн байдлын тайлангийн дансны жагсаалтыг шинэчлэн баталсан;

- Гэмтлийн зэрэг тогтоох үзлэгийн төлбөр 8.0 мянга, задлан шинжилгээ хийх төлбөр 60.0 мянган төгрөг байсан ба төлбөрийг байгууллагын үндсэн дансанд төвлөрүүлдэг байсныг дээд газрын шийдвэрээр гэмтлийн зэрэг тогтоох үзлэгийг үнэ төлбөргүй болгосон, харин задлан шинжилгээ хийх төлбөрийг 80.0 мянган төгрөг болгож, төлбөрийг орон нутгийн 100030000941 тоот дансанд төвлөрүүлдэг болсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ШШЕГ-ын 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/100 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаанд мөрддөг, тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хуулийн дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,068,813.3 мянган төгрөгөөр буюу 78.46 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	10,241.0	5,487.5	(4,753.5)
Үндсэн хөрөнгө	1,483,913.1	390,457.4	(1,093,455.6)
Хуримтлагдсан элэгдэл	(131,846.7)	(102,450.9)	29,395.8
Нийт хөрөнгө	1,362,307.3	293,494.0	(1,068,813.3)

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,362,307.3	293,494.0	(1,068,813.3)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,362,307.3	293,494.0	(1,068,813.3)

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн 2023 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан данс нь бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тус байгууллагын бараа материалын эхний үлдэгдэл өмнөх онд 10,240.9 мянган төгрөг байсан ба тайлант онд төсвийн хөрөнгөөр 47,669.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 52,422.5 мянган төгрөгийн бараа материал акталсан ба тайлант онд эм боох материал, түлш шатах тослох материалыг нөөцлөөгүйтэй холбоотой бараа материалын үлдэгдэл өмнөх оноос буурсан байна.

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл өмнөх оноос 1,093,455.6 мянган төгрөгөөр буурч, 390.5 мянган төгрөг болсон нь төсвийн хөрөнгөөр 17,949.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 33 дугаар тогтоолоор тус байгууллагад 2023 онд шилжиж ирсэн 1,172,168.2 мянган төгрөгийн өртөг бүхий хуучнаар Мэргэжлийн хяналтын газрын байрыг, 74,625.0 мянган төгрөгийн газрын хамт Баянхонгор аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтэст балансаас баланст шилжүүлсэнтэй холбоотой байна.

ШШЕГ-ын даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/125 дугаар тушаалаар 16,766.9 мянган төгрөгийн 4 нэр төрлийн 9 ширхэг машин тоног төхөөрөмж, ТӨБЗГ-ын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 740 дүгээр тогтоолоор 141,361.4 мянган төгрөгийн тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл ирснийг үндсэн хөрөнгөд бүртгэжээ.

ТӨБЗГ-ын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 746 дугаар тогтоолоор тус байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 32,888.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг баланст дахин үнэлж, 10,148.1 мянган төгрөгөөр дахин үнэлсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 1,068,813.2 мянган төгрөгөөр хасагдан, 293,494.0 мянган төгрөг болсон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төслийг 356,170.8 мянган төгрөгөөр төлөвлөж, Шүүх шинжилгээний Ерөнхий газарт хүргүүлсэн байна.

Шүүх шинжилгээний Ерөнхий газар хүргүүлсэн төсвийн төслийг 70,541.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн анхны төсвийн хуваарийг 426,711.9 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Анхны баталсан төсвийг 2024 онд 5 удаагийн тодотголоор нийт 66,232.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 492,944.2 мянган төгрөгөөр баталж, тайлант онд баталсан санхүүжилтийг улсын төсвөөс бүрэн олгожээ.

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70707 (Шүүхийн шинжилгээ) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс олгосон санхүүжилтийн 99.3 хувь буюу 489,674.4 мянган төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулж, зардлын хэмнэлтийн 3,269.8 мянган төгрөгийг оны эцэст улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
70707	Шүүхийн шинжилгээ				
	АРГА ХЭМЖЭЭ 80101	490,045.2	486,775.4	3,269.8	99.33
	АРГА ХЭМЖЭЭ 80835	1,899.0	1,899.0	-	100.00
	АРГА ХЭМЖЭЭ 82311	1,000.0	1,000.0	-	100.00
	ДҮН	492,944.2	489,674.4	3,269.8	99.34

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн төсвийн хэлбэлзэл

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн ИТХ-аас хуваарилсан 10,000.0 мянган төгрөгийг аймгийн ИТХ-ын даргын 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 67 дугаар захирамжийн дагуу сургалт зохион байгуулахад зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх тухай 22/29 дүгээр албан бичгийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 16-ны

өдөр санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт, материалын хамт ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант жилийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоосон.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсвийн 486,536.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,865.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 3,162.5 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Баянхонгор аймгийн Шүүх шинжилгээний хэлтэс нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагад завсрын аудитыг гүйцэтгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тус байгууллага түүвэрт хамрагдсан, аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Цэвээнсүрэн гүйцэтгэж, аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шүүх шинжилгээний Ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн Б/554 дүгээр тушаалаар байгууллагын 8 албан хаагчид 1 сарын цалинтай тэнцэх хэмжээний урамшуулалд нийт 11,372.3 мянган төгрөгийг олгосон байгаа тул цаашид тус асуудлыг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах нь зүйтэй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлангийн аудитаар залруулсан алдаа байхгүй.

Аудитаар 260,573.9 мянган төгрөгийн 1 зөрчил¹ илэрсэнд зөрчлийг арилгах албан шаардлага өглөө.

5.1. Албан шаардлага

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 217,328.0 мянган төгрөгийн 7 гүйлгээ, байгууллагын даргын иргэн, аж ахуйн нэгжтэй байгуулсан 43,245.8 мянган төгрөгийн 8 гэрээг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.8 дахь “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст орхигдуулсан мэдээллийг нөхөн байршуулах албан шаардлагыг хүргүүлэв.

Аудитаар өгсөн албан шаардлагын биелэлтийг бүрэн биелүүлж, хэрэгжилтийг нотлох баримтын хамт төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан нягтлан бодогчид талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 217,328.0 мянган төгрөгийн 7 гүйлгээ, байгууллагын даргын иргэн, аж ахуйн нэгжтэй байгуулсан 43,245.8 мянган төгрөгийн 8 гэрээг байршуулаагүй байна.	1	260,573.8			1	260,573.8		
Дүн	1	260,573.8	0	0	1	260,573.8	0	

---oOo---

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.